

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
V. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	33
X. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
XI. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	37
Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /*Google earth/	4
Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /*Google Earth-2024/	4
Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэл	5
Зураг 4. Өдөөгчийн үйлдвэр	6
Зураг 5. Нонель хэрэгсэл угсрах үйлдвэр	6
Зураг 6. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах	7
Зураг 7. Захиргаа, аж ахуйн барилгын харагдах байдал	7
Зураг 8. Тусгайлан тоногдсон туршилтын талбай	8
Зураг 9. Үйлдвэрийн хяналтын лаборатори	8
Зураг 10. Үйлдвэр агуулахын агааржуулалтын систем	12
Зураг 11. Агуулахын агааржуулалтын систем	12
Зураг 12. Түүхий эдийн агуулах	12
Зураг 13. ГТБЧХБ-ны тайлан	15
Зураг 14. Сайжруулсан зам, тэмдэг тэмдэглэгээ	15
Зураг 15. Ахуйн хог хаягдал ангилах сав	15
Зураг 16. Түүхий эдийн сав, баглаа, боодол түр хадгалах цэг	15
Зураг 17. Үйлдвэр агуулах болон материал хүлээн авах талбай	16
Зураг 18. Шингэн хаягдал хүлээж авах гэрээ	18
Зураг 19. Үерийн далан, шуудуу	18
Зураг 20. Авто машины зогсоол	18
Зураг 21. Журам	21
Зураг 22. Эмнэлгийн үзлэгт хамрагдсан тайлангийн нүүр	21
Зураг 23. Онцгой байдлын албатай хамтарсан сургалт	21
Зураг 24. Галын аюулгүй байдлын дүгнэлт	21

Зураг 25. Хөдөлмөрлөх нөхцөлийн үнэлгээ хийлгэх гэрээ .....	22
Зураг 26. Байгаль орчны аудит хийлгэх гэрээ .....	22
Зураг 27. Налайх дүүрэгт мод тарьж буй үйл явц .....	24
Зураг 28. Химийн бодис, аюулгүй байдал, анхан шатны тусламж, галын аюулгүй байдлын тухай сургалт .....	27
Зураг 29. Ажлын байрны үзлэгийн хуваарь, таг.....	28
Зураг 30. Галын сараа, гал унтраах багаж хэрэгсэл, яаралтай тусламжийн хайрцаг.....	28
Зураг 31. Авто машины үзлэг, өдөр тутмын эрсдэлийн үнэлгээ .....	29
Зураг 32. Эрүүл мэнд, үзлэгийн өрөө .....	29
Зураг 33. Хог хаягдлын ангилан ялгах журам, сургалт, устгах гэрээ .....	31
Зураг 34. Хог хаягдлын гэрээт байгууллага.....	31
Зураг 35. Орчны мониторинг, хяналт шинжилгээ.....	34
Зураг 36. Мод тарих өдөрлөг, боловсролын өдөрлөг .....	36
Зураг 37. Бүх нийтийн цэвэрлэгээ .....	36

## I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн хэрэгжүүлэгч:**

“MERA”ХХК

**Төслийн нэр:**

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011108011

**Регистрийн дугаар:** 2619687

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Монгол улс-210644, Улаанбаатар хот | Сити Тауэр /17 давхарт/, Чингис хааны нэрэмжит талбай 1, 8-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14200

**Утас:** 75 55 66 77 **Факс:** 11 319276 |

**Төслийн байршил.**

Налайх дүүргийн Засаг Даргын 2022 оны 08-р сарын 17-ны өдрийн А/228 тоот шийдвэрийг үндэслэн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1261610685 нэгж талбарын дугаар бүхий 158054 м<sup>2</sup> газрыг (15.8 га) үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр гэрчилгээ олгогдсон. ҮАЦ нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 45км, Налайх дүүргийн төвөөс баруун урагш 2.4 км зайтай байрладаг.

*Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол*

#	X	Y
1	47° 44.727'N	107° 15.022'E
2	47° 44.726'N	107° 14.813'E
3	47° 44.754'N	107° 14.769'E
4	47° 44.870'N	107° 14.767'E
5	47° 44.871'N	107° 14.890'E
6	47° 44.925'N	107° 14.890'E
7	47° 44.929'N	107° 15.117'E
8	47° 44.668'N	107° 15.118'E
9	47° 44.669'N	107° 15.022'E

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагын дагуу үйлдвэр нь байнгын их хөдөлгөөнтэй зам, улсын чанартай объект, хүн ам бүхий сууринаас нэг километрийн зайтай байх, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эдээ төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамд холбогдох боломжоор хангагдсан байх шаардлагыг үндэслэн үйлдвэрийн байрлалыг Налайх-Чойр чиглэлийн автозамаас 950 метр, Улаанбаатар-Замын үүд чиглэлийн төмөр замаас 15 км зайд, цэргийн локаторын ангиас 930 метр алслагдсан зайд сонгон байгуулсан.



*Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /\*Google earth/*



*Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /\*Google Earth-2024/*

### Төслийн хүчин чадал

Тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор нь одоогийн байдлаар нийт 40 ажилтан, албан хаагчтай ба 4 ээлжээр ажиллаж жилд 6.0 мян.тонн савлагаатай хүчитгэсэн болон хүчитгээгүй энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай.

Тэсрэх материалын агуулахын нийт багтаамж 2008 оны байдлаар 200 тн байсан ба 2011 онд 150 тн багтаамжтай түүхий эдийн агуулахуудыг нэмж барьсан. 2018 оны байдлаар агуулахын ерөнхий багтаамж 120 тн болсон.

### Химийн бодисын хэрэглээ.

Тэсрэх бодисын үйлдвэрийн технологит доорх нэр төрлийн химийн бодисуудыг ашигладаг ба 1 төрлийн бэлэн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирж компани өөрийн үйл ажиллагаанд хэрэглэн тэсэлгээний ажил үйлчилгээ гүйцэтгэх ба зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид худалдаалах ажлыг явуулдаг. Аммонийн нитрат (аммиакийн шүү), дизелийн түлш, хөнгөн цагааны нунтаг зэрэг химийн бодисыг үйлдвэрийн технологийн үйлдвэрлэл буюу бүтээгдэхүүний найрлагын түүхий эд байдлаар ашигладаг.

### Энгийн тэсрэх бодисын үйлдвэр

Улаанбаатар хотын Налайх дүүрэгт 2006 онд энгийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулснаар Монгол улсад үндэсний хөрөнгө оруулалттай анхны тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор байгуулагдсан. Уг үйлдвэрийн цогцолборт АНУ-д үйлдвэрлэсэн, энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх иж бүрэн суурин тоног төхөөрөмж, энгийн тэсрэх бодис үйлдвэрлэн цооногт цэнэглэгч автомашинууд, бүтээгдэхүүний чанарт хяналт хийх зориулалт бүхий лаборатори, туршилтын полигон багтаж байгаа бөгөөд бүтээгдэхүүний орц найрлагыг хянах, тоо хэмжээ тоолох удирдлагын автомат системээр тоноглогдсон орчин үеийн үйлдвэр юм. Үйлдвэр нь энгийн тэсрэх бодисыг тухайн газрын чулуулгийн хатуулаг, орчны шинж чанарт тохируулан Энгийн буюу "Аянга", Хүчитгэсэн буюу "Аянга-Х", Усанд тэсвэртэй буюу "Аянга-УТ" гэсэн 3 төрлөөр үйлдвэрлэж, полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлан, мөн 76мм, 101мм, 127мм-ийн голчтой олгойлон уутанд савлаж байна.



Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэл

### Өдөөгчийн үйлдвэр

Монгол Улсын уул уурхай, зам, барилгын салбарын тэсэлгээний ажилд 100% импортлон ашиглаж буй өдөөгчийг үйлдвэрлэнэ. Энэхүү өдөөгч нь сул мэдрэх чадвартай тэсрэх бодис болон тэсэлгээний үндсэн цэнэгийг өдөөж тэслэх зориулалттай. Уул уурхай, зам, барилгын тэсэлгээнд хэрэглэх зорилгоор төрөл бүрийн хэмжээгээр үйлдвэрлэдэг бөгөөд жилд 500 тонн өдөөгч үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 4. Өдөөгчийн үйлдвэр

### Тэсэлгээний хэрэгсэл угсрах үйлдвэр

Уул уурхайн салбарт чанартай, хямд, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, компанийн үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-ийн Аустин детонатор компанийн жилд 500,000 ширхэг цахилгаан бус хэрэгсэл угсрах хүчин чадал бүхий үйлдвэр юм.



Зураг 5. Нонель хэрэгсэл угсрах үйлдвэр

### Агуулахууд

Үйлдвэрийн агуулахууд нь түүхий эд, туслах материалын, импортын эмульсийн тэсрэх бодисын, тэсэлгээний хэрэгслийн, бүтээгдэхүүний (ANFO) гэж ангилагдах бөгөөд агуулахын хамгийн их багтаамж нь (аммиакийн шүү орохгүйгээр)-1200 тн, үүнээс ЭТБ-100 тн, Эмульсийн тэсрэх бодис-1100 тн, аммиакийн шүү-1500 тн, бусад тэсэлгээний хэрэгсэл хадгалах хүчин чадалтай.

Налайхын тэсрэх бодис, түүхий эд материалын агуулахуудыг ТАААНД-ийн шаардлагын дагуу тоноглон бөгөөд эдэлбэрийн зүүн хэсгийг шороон далангаар тусгаарлан, аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан дөрөв дөрвөөр нь зэрэгцүүлэн барьсан. агуулахуудад хадгалдаг.



*Зураг 6. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах*

### **Захиргаа аж ахуйн барилга**

Үйлдвэрийн захиргаа, аж ахуйн хэсэг үйлдвэрийн хойд хэсэгт байрладаг давхар барилгын баруун жигүүрт байрладаг ба өнгөрсөн хугацаанд барилга дотор явуулж буй үйл ажиллагаанд өөрчлөлт оруулаагүй. 2020 онд орон тоо нэмэгдэж буйтай холбоотой оффисын барилгад өргөтгөл хийж, ажиллах нөхцөл, орчныг сайжруулахаар төлөвлөн, ажлын зураг хийлгэж бэлэн болсон.

Энэхүү барилгад тус албан контор, ажилчдын цайны газар, ажилчдын 1 ээлжийн душ, хувцас угаалгын хэсэг, халаалтын блок, хувцас солих өрөө гэх мэт өрөө тасалгаануудтай ба лабораторийн хэсэг нь 2-р бүс рүү нэвтрэх харуулын постын хажууд байршина.

Мөн үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга зэрэг шаардлагатай газруудад 72 ширхэг хяналтын камер байрлуулан интернэтийн сүлжээтэй байрлалаас 24 цагийн турш хянаж байна.



*Зураг 7. Захиргаа, аж ахуйн барилгын харагдах байдал*

### Үйлдвэрийн лаборатори

Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүний чанарын хяналтыг үйлдвэрийн лабораториор хянаж ажилладаг ба үйлдвэрийн гадна талбайд зөвшөөрөгдсөн зайд тусгайлан тоноглож байгуулсан туршилтын талбайд бүтээгдэхүүний туршилтын ажлыг мэргэжлийн эрх бүхий үнэмлэхтэй тэсэлгээчид гүйцэтгэдэг.



Зураг 9. Үйлдвэрийн хяналтын лаборатори



Зураг 8. Тусгайлан тоногдсон туршилтын талбай

### Хүснэгт 2. Лабораторид гүйцэтгэж буй сорилтууд

Сорилт хийх материалын нэр	Гүйцэтгэж байгаа сорилтын төрөл
Аммонийн нитратын механик сорилт	Шингээх чадвар
Дизель түлшний үзүүлэлтүүд	Хүлээн авах үеийн хяналт
“Аянга” бүтээгдэхүүний түүхий эд	Орц найрлага
Тэсрэх бодисын өдөөгч	Өдөөлтийн эрчим, хүч



## II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Физик газарзүй:

Налайх дүүрэг нь газарзүйн байршлын хувьд Хэнтийн уулархаг мужид хамаарагдана. Геоморфологийн хувьд голын татмын дэвсгэр нутаг болох бөгөөд голын татмаар нэвчилт шүүрэлт ихтэй сийрэгдүү, элс сайр, сайрган, хайргархаг аллювийн хурдас зонхилно.

### Цаг уур, уур амьсгал:

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс цаг агаарын шинжтэй, хот орчмын бичил, бэсрэг уур амьсгалын онцлогтой. Налайх орчмын агаарын температур өвөл 18.80 - 22.70, зун 12.80 - 15.40, Жилд унах тунадасны хэмжээ 260-290 мм, жилийн дундаж агаарын даралт 852.3 гПа, дундаж салхины хурд жилд 4.2 м/с байна.

### Гадаргын болон газар доорх ус:

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор орчимд гадаргын ус байхгүй. Налайх орчмын гидрогеологийн зурагт тэмдэглэснээр Налайхын нүүрсний уурхай орчимд Туул голын хөндийд газрын доорх устай аллювийн хурдас, Налайхын хотгорт их талбайд тархалттай, бага нөөцтэй газрын доорх устай доод цэрдийн хурдас, үндсэндээ усгүй неогений хурдас тус тус тархсан байна.

### Хөрс, ургамал, амьтан:

Хөрс газарзүйн мужлалаар уулын хар хүрэн, хар шороон, уулын тайгын ширэгт, уулын ойн бараан хөрстэй Хэнтийн өмнөт тойрогт багтдаг. Үйлдвэр байрлаж буй газрын хэмжээнд хээрийн хөнгөн шавранцар хар хүрэн хөрс зонхилон тархана.

Ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана. Налайхаас зүүн урагш Баянгийн овоо, Баян-Уул хүртэл уулын хээрийн хөнгөн шавранцар хөнгөн хөрстэй, жижиг үетэн-алаг өвст, чулуурхаг нам толгодоор үетэн-алаг өвст-үетэн-агьт бүлгэмдэл тааралдана. Налайх суурингийн орчим Хонхор нуур хүртэл нам толгодын бэл хөндийгөөр үетэн-агьт, үетэн-алаг өвс-шарилжит, үетэн шарилжит бүлгэмдэлтэй талхлагдсан бэлчээр зонхилно.

Амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Налайх дүүрэг орчимд цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад багтана.

### Нийгэм-эдийн засаг:

Налайх дүүрэг нь Засаг захиргааны 7 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Монгол Улсын авто замын босоо болон хэвтээ тэнхлэгийн огтлолцолд оршдог, авто зам, төмөр зам, агаарын тээвэр хөгжсөн, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй, нийслэлийг цэвэр усаар хангаж байгаа дээд эх үүсвэртэй шууд холбогдсон, Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхыг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ихтэй зэрэг давуу тал олон.

### III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх, автомашины хөдөлгөөнөөс үүдэн зам орчмын ургамлан бүрхэвчид нарийн ширхэгт тоос тогтож улмаар ургалтад нь сөргөөр нөлөөлөх зэргээр үйлдвэр агуулахын цогцолбор төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой байдаг.

#### **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЗОРИЛТ**

“МЕРА” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2024 онд зорилт болгон ажиллаж байна.

- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгах.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар MNS ISO 14001:2016” стандартын хэрэгжилтийн нийцтэй байдлын талаарх магадлах гадаад аудитыг хийлгэж, байгальд сөрөг нөлөөлөл багатай техник, технологиор үйл ажиллагаагаа явуулж, учирч болзошгүй эрсдэлүүдийг байнгын хяналтдаа байлгах.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлох.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

#### IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөсөн зардал (төгрөг)		Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
<b>Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах</b>								
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	T14 үйлдвэрийн ажиллах орчны агаарын чанарын урсгалыг сайжруулах	Төслийн барилга байгууламж	Дотоод хяналтаар			2024 онд	Үйлдвэр, агуулахын агааржуулалтын системийн хэвийн ажиллагаанд тогтмол үзлэг шалгалт хийж байна. <i>Зураг-10</i>
2		Ажлын байр, агуулах, авто засвар автогаш зэрэг барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах	Төслийн барилга байгууламж	₮ 2,500,000	₮ 0		2024 онд	Үйлдвэр, агуулах, оффис, гал тогоо нь автомат болон байгалийн агааржуулалтын системтэй ба агаар сэлгэлт сайн байдаг.
3		Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах	Төслийн хэмжээнд	Дотоод зардлаар			2024 онд	Хөдөлмөрлөх орчны нөхцөлд хийсэн шинжилгээгээр үйлдвэрлэлийн орчин, ажлын байран дахь шуугиан стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд гэж гарсан. Шаардлагатай үед хэрэглэх сонголт хамгаалах хэрэгслийг бэлэн байлгаж байна.
4		Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах.	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр			Тогтмол	Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийг цахилгаан эх үүсвэр, нарны шууд тусгал тусахааргүй тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон бусад хууль тогтоомжийн шаардлагыг хангасан агуулахад хадгалж байна.
5	Авто машин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Төслийн хэмжээнд	Дотоод хяналтаар			Тогтмол	Салбарын хэмжээнд ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгслийг жилд нэг удаа, аюултай ачаа тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг жилд 2 удаа улсын үзлэгт хамруулж техникийн бэлэн байдал, аюулгүй байдалд анхаарч ажиллаж байна.
	<b>Нийт зардал</b>			₮ <b>2,500,000</b>	₮ <b>0</b>			



Зураг 11. Агуулахын агааржуулалтын систем

Зураг 12. Түүхий эдийн агуулах



ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбайд	ОХШХ-т тусгав.		Жилд 1-2 удаа	ОХШХ-т тусгав.
2		Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг хуульд заасан хугацаанд хийлгэх	“Мера” ХХК	Дотоод төлөвлөлтөөр		5 жилд 1 удаа	ГТБЧХБ хийх эрх бүхий Дойтын булаг ХХК-аар хийлгэж цаашид авах арга хэмжээ, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар арчилгаа, усалгаа хийх	Төслийн хэмжээнд	760,000	300,000	Жил бүр 2 удаа	Тус онд үйлдвэр болон Налайх-Чойр чиглэлийн авто зам хооронд сайжруулсан шороон зам тавьж авто машины зогсоолыг хайргаар тэгшилж тоосжилт үүсэхээс сэргийлсэн. Шинээр тавьсан сайжруулсан зам дагуу тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. <i>Зураг-14</i>
4		Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих	Төслийн хэмжээнд	Дотоод зардлаар		Тогтмол	Тээврийн автомашинууд нь GPS төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд хурдны хязгаарыг мөрдөж байгаа эсэхийг системээр тогтмол хянаж ажилладаг. Үйлдвэрийн бүс рүү автомашин нэвтрүүлэхэд хурдны хязгаарын талаар мэдээллийг өгч ажилладаг.
5	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрс бохирдох	Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах	Төслийн хэмжээнд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав		Төсөл хэрэгжих хугацаанд	Төслийн хэмжээнд ахуйн хог хаягдлын ангилан хаях хогийн савуудыг байршуулж ажилчдыг тогтмол мэдээллээр хангаж ажилладаг. Хог хаягдлын цэгийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулсан. Ахуйн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлж Налайх дүүргийн ТӨҮГ-т гэрээний дагуу ачуулж устгуулдаг. <i>Зураг-15</i>

6		Хог хаягдлын сав, цэгийн тохижилт, засвар үйлчилгээг тогтмол хийх	“Мера ХХК”	₮ 1,400,000	₮ 0	Улирал тутам	Хог хаягдлыг үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг зориулалтын бүсэд байршуулж байна. Үйлдвэрийн бүсэд хог ангилан хаях зориулалтын аюултай болон энгийн хог хаягдлын сав мөн хуванцар хаягдал цуглуулах сагсыг байршуулсан. Аюултай хог хаягдлын бүсэд тогтмол хяналт, үзлэг хийдэг бөгөөд үл тохирол илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээг цаг тухай бүрд нь авч ажиллаж байна. <i>Зураг-16</i>
7	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдон гарах нөлөөлөл	Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах	Төслийн хэмжээнд	Дотоод зардлаар		Үйл ажиллагааны туршид	Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд зориулалтын агуулахад хадгалдаг. <i>Зураг-12</i>
8		Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд дор нь засварлах.	Төслийн хүрээнд	Дотоод зардлаар		Өдөр тутмын үйл ажиллагаанд	Үйлдвэр агуулах болон материал хүлээн авах талбайд тогтмол хяналт шалгалт хийж асгаралтаас сэргийлж ажилладаг.
<b>Нийт зардал</b>				₮ <b>2,160,000</b>	₮ 300,000		

Зураг 13. ГТБЧХБ-ны тайлан

Зураг 14. Сайжруулсан зам, тэмдэг тэмдэглэгээ



Хөрөнгийн хүнд металлын угуулалт

Дүгэм 7. Хөрөнгийн хүнд металлын угуулалтууд

Дээж авсан түүн (см)	Хүнд металлын агуулгаж (мг/кг)					
	Хром (Cr)	Хар тугалга (Pb)	Кадми (Cd)	Никель (Ni)	Цайр (Zn)	Зэс (Cu)
Эгс-1	0.20	15.7	33.4	0.0	14.2	79.8
Эсвэрж хөрөнгө агуулахад хэмжээ MNS 5850 : 2019	60	50	1	60	100	60
Шаварныг хөрс MNS 5850 : 2019	100	70	1.5	100	150	80
Шаварныг хөрс MNS 5850 : 2019	150	100	3	150	300	100

Хөрөнгийн дэвжэнд хүнд металлын шинжилгээг атомын шингэлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан 1P дүн (MNS 5850:2019) Хөрөнгийн ханга. Хөрөнгө агуулахад бохирдуулах болсон зөвшөөрөгдөх дээж хэмжээ стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээж хэмжээгээ даваагүй байна.

MNS 5850 : 2019 стандартаг нь хөрс бохирдуулагч болсноор зөвшөөрөгдөх дээж хэмжээний 3 зоргоод хуваах: Үүл:

- Хүлхц агууламж
- Хортгой агууламж
- Аюултай агууламж

Дүгнэ агууламж: бохирдуулагч болон, элементийн хөрөнгө агуулахад хэмжээ нь хүлхц агууламжаас дээш гарсан тохиолдолд хөрс бохирдлын түвшинд хүрнэ гэж үзнэ. Хүлхц агууламж болон зөвшөөрөгдөх дээж хэмжээ нь адал утгатай. Хүлхц агууламжийг хүч ач оршин сууны суурин газар, хамаа аж ахуйн хэлбэр, газар тариалан, бэлчээрийн хэлбэр газарууд мөрдөг болгоно.

Хортгой агууламж: хөрөнгө агуулахад бохирдуулагч болон, элементийн хэмжээ нь хортгой агууламжаас дээш гарсан тохиолдолд тухайн хөрс нь орчин тойронд байгаа амьт оршин, усан давхаргад хортгой аюул учруулж хэлнэ. Хортгой агууламжийг тусгай зөвшөөрөгдөх үйлдвэрлэл, уурз тухай бүрэд бохирдуулагч болон, элементийн хөрөнгө агуулахад зөвшөөрөгдөх дээж хэмжээг адал утгаар мөрдөг болгоно.

Аюултай агууламж: хөрөнгө агуулахад бохирдуулагч болон, элементийн хэмжээ нь аюултай агууламжаас дээш гарсан тохиолдолд хөрөнгийн бохирдлыг аргаар харагдай дээж хэмжээ авч шавардлагай. Тухайлбал сармыгжуулах, угаж зайлуулах, газар ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, оршин суугчдыг илүүгн шилжүүлэх гэх мэт.



Зураг 15. Ахуйн хог хаягдал ангилах сав

Зураг 16. Түүхий эдийн сав, баглаа, боодол түр хадгалах цэг






УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Бараа материалын тээвэр хийх хүнд машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх	Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		Тогтмол	Ахуйн хуурай хог хаягдлыг контейнерт түр хадгалдаг. Үйлдвэрийн бүс дэх зогсоол суваг, шуудуунаас хол байрладаг.



2	Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Төслийн үйлдвэр болон агуулах орчмын үерийн хамгаалалт, даланд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	Төслийн хэмжээнд	₮ 200,000	₮ 0	2024 онд	Үйлдвэр, агуулахын гэнэтийн халдлага, гал, үерээс хамгаалах далан шуудуунуудад улирал бүр үзлэг шалгалт хийж, засварлах, хог хаягдлыг нь цэвэрлүүлэх ажлыг хийж гүйцэтгэдэг. <i>Зураг-19</i>
3	Үйлдвэр ахуйн ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Үйлдвэрийн оффис	₮ 3,060,000	₮ 880,000	2024 онд	Бохир усыг зориулалтын саванд хуримтлуулан гэрээний дагуу “Маргад-эрдэнэ” ХХК-д тушааж байна. <i>Зураг-18</i>
<b>Нийт зардал</b>				<b>₮ 3,260,000</b>	<b>₮ 880,000</b>		



Зураг 18. Шингэн хаягдал хүлээж авах гэрээ



Зураг 19. Үерийн далан, шуудуу



Зураг 20. Авто машины зогсоол

Ургамлан бүрхэвчийг хамгаалах арга хэмжээ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврын тогтмол хянах	Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд			Жилд удаа 1-2	Үйлдвэрийн бүсэд хиаг, ширэг улалж, ерхөг, хазаар өвс зэрэг бэлчээрийн болон харганын төрлийн ургамал тархсан. Дундаж өндөр 10-16см, тусгаг бүрхэц 45-55% байна.
2	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	Төслийн талбайд	Нөхөн сэргээлт ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав			Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ ХЭМЖЭЭ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1		Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид		Дотоод зардлаар	Үйл ажиллагааны туршид	“Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох журам”-ын дагуу НБХХ, ажил үүргийн нөхцөлд тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр цаг тухай бүрд бүрэн хангадаг. <i>Зураг-21</i>
2	Хүний эрүүл мэнд	Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах		₮ 1,000,000	₮ 10,150,000	Жилд нэг удаа	Бүх ажилчдыг ажилд авч ээлжинд явуулахын өмнө бүтэн биеийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт зайлшгүй хамруулдаг. 2024 онд Сонмедикал болон 4-р эмнэлэгт ажилчдыг эрүүл мэндийн багц үзлэгт хамруулсан. <i>Зураг-22</i>
3		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах		₮ 3,000,000	₮ 27,500,000	Үйл ажиллагааны туршид	“Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох журам”-ын хавсралтын дагуу ажилтан бүрийг НБХХ, ажлын тусгай

							хувцсаар цаг тухай бүрд бүрэн хангадаг. <i>Зураг-21</i>
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах		₮ 1,000,000	₮ 0	2024 онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар дотоод, гадаад сургалт зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулж мэдлэг олгосон. <i>Зураг-23</i>
5	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Галын аюулгүй байдлын дүгнэлт	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр			2 жилд 1 удаа	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох мэргэжлийн албаар гаргуулсан ба дүгнэлтийн дагуух зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилладаг. <i>Зураг-25</i>
6	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр			Жилд 1 удаа	Жил бүр ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулдаг ба энэ онд 9 сард гэрээ байгуулагдан хийгдэж байна. <i>Зураг-26</i>
7	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	₮ 10,000,000	₮ 8,500,000	2 жилд 1 удаа	Байгаль орчны аудит хийх тусгай зөвшөөрөлтэй компани болох “Мархал Тал” ХХК-аар салбарын байгаль орчны аудитыг хийлгэж байна. <i>Зураг-27</i>
	<b>Нийт зардал</b>			₮ <b>15,000,000</b>	₮ <b>46,150,000</b>		



Зураг 25. Хөдөлмөрлөх нөхцөлийн үнэлгээ хийлгэх гэрээ



Энэхүү гэрээг /цаашид "Гэрээ" гэх/-г нэг талаас /цаашид "Захиалагч" гэх/ "МЕРА" ХХК-ийг төлөөлж ХАБЭАБО-ны хэлтсийн дарга нөгөө талаас "МӨНХ ЧАНДМАНЬ ХҮРД" ХХК-ийн "МСН" үнэлгээний төв /цаашид "Гүйцэтгэгч" гэх/-ийг төлөөлөн менежер Д.Алгаа /цаашид хамтад нь "Талууд" гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч талаас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Захиалагч талын ирүүлсэн хүсэлтийн дагуу "МЕРА" ХХК-ийн гэрээний нэгдүгээр хавсралтад тусгагдсан ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, судалгаанд тулгуурлан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд оршино.
- 1.2 Гэрээний ач холбогдол нь Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхтэй холбогдон Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

**Хоёр. Хийгдэх ажил, гүйцэтгэх хугацаа**

- 2.1 Гүйцэтгэгч тал 1-р хавсралтад заасан ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.1.1 Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрээний нэгдүгээр хавсралтад тусгагдсан ажлын байрнуудад хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээг хийж гүйцэтгэх.
  - 2.1.2 Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайлан, дүгнэлтийг хэмжилт дууссан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан Захиалагч талд хүлээлгэн өгөх.
- 2.2 Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг 2024 оны 09 сарын 30-ны өдрөөс эхлэн ажлын 14 хоногт гүйцэтгэх үүрэгтэй.

2024 оны БОМТ-ын тайлан  
Зураг 26. Байгаль орчны аудит хийлгэх гэрээ



Энэхүү гэрээг нэг талаас "Грийн солишн консалтинг" ХХК-ийг төлөөлж тус компанийн захирал ажилтай Б.Тунсаг (цаашид "Гүйцэтгэгч" гэх), нөгөө талаас "МЕРА" ХХК-ийг төлөөлөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтсийн дарга албан тушаалтай Б.Цогбадрах (цаашид "Захиалагч" гэх) нар (хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

